




МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ: АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮН

68.4%

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД НИЙТ 136 ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ ТУСГАЖ БАТАЛСНЫ 68.4 ХУВЬ НЬ БИЕЛСЭН БАЙНА.

ДЭВШҮҮЛСЭН НИЙТ 136 ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:



- Хэрэгжсэн
- Хэрэгжилт дутуу
- Хэрэгжээгүй

ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ:

- Макро эдийн засгийн бодлого - **70%**
- Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого - **51.9%**
- Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого - **65%**
- Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого - **75.6%**
- Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад болон батлан хамгаалах салбарын бодлого - **82.9%**

ХЭРЭГЖЭЭГҮЙ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ



Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх



Жижиг, дунд үйлдвэр, хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх



Эрдэнэт хотод зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр барих



Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станцын барилгын ажил



Аймгийн төвүүдэд байгаль орчинд ээлтэй дулааны станц, шугам сүлжээ барих ажлыг үргэлжлүүлэх



Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын төслүүдийг үргэлжлүүлэх



Говь-Алтай-Баянхонгор-Улаанбаатарын баруун чиглэлийн хатуу хучилттай авто замын "Хүйтний хөндий" дэх засварын ажлыг гүйцэтгэх



Зарим их, дээд сургуулийг Дархан-Уул, Орхон, Багануур, Сэлэнгэ аймагт нүүлгэн шилжүүлэх ажлыг эхлүүлэх



Нийтийн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн үйлчилгээг төрөөс дэмжих



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ

62.4% ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСВИЙН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ 62.4 ХУВЬ БАЙНА.





Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээнд нийт **7771.4 тэрбум** төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр төлөвлөгдсөнөөс урьдчилсан дүнгээр **4847.9 тэрбум** төгрөгийн ажил хийгджээ.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БА ГҮЙЦЭТГЭЛ (тэрбум төг.)


№	Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Улсын төсөв	772	1072.2	-300.2
2	Орон нутгийн төсөв	0.6	0.04	0.6
3	Төр, хувийн хэвшлийн түншлэл	482.0	-	482.0
4	Хувийн хэвшил	4145.7	2836.1	1309.6
5	Гадаад эх үүсвэр	1541.5	727.1	814.4
6	Бусад	829.6	257.5	572.1
	Нийт	7771.4	4847.9	2923.5

САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ (эзлэх хувийн жингээр)

ТӨЛӨВЛӨГӨӨ



ГҮЙЦЭТГЭЛ



- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс төлөвлөсөн хэмжээнээс 38.9 хувиар илүү санхүүжилт олгожээ.
- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний санхүүжилтийн 58 хувийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлжээ.
- Монгол Улс ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдаж шинээр концессын гэрээг хязгаарласнаар төлөвлөгдсөн 3434.4 тэрбум төгрөгийн хувийн хөрөнгө оруулалт, гадаад эх үүсвэрийн санхүүжилт хийгдээгүй.



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ЗӨВЛӨМЖ



УЛСЫН ИХ ХУРЛЫН АНХААРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэлэлцэж, шийдвэр гаргахдаа хууль тогтоомжийн дагуу нөхцөл байдлын судалгаа хийгдсэн, санхүүжилтийн эх үүсвэрийг нь бүрэн тооцсон зорилт, арга хэмжээг баталж байх;
- Монгол Улсын Засгийн газар жил бүр үндсэн чиглэлийн биелэлтийн тайланг УИХ-д хүргүүлсний дараа аудитын дүгнэлт гаргуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх.



САНГИЙН САЙДАД:

- Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахад салбарын яам, хариуцан хэрэгжүүлэгч байгууллагатай хийх зөвшилцөл, хэлэлцүүлгийг баримтжуулах, тэргүүлэх ач холбогдол бүхий тодорхой үр дүнд чиглэсэн зорилт, арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэртэй нь уялдуулан төлөвлөж, нэгтгэн тайлагнахад анхаарах.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ:

- Үндсэн чиглэлийн зорилт арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, холбогдох журмын дагуу нөхцөл байдлын шинжилгээ, тооцоо судалгаанд үндэслэн оновчтой төлөвлөх, санхүүжилтийн эх үүсвэр, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг бодитой хэрэгжих, үнэлэх боломжтойгоор боловсруулж байх;
- Үндсэн чиглэлийн биелэлтийг тайлагнахдаа шалгуур үзүүлэлттэй нь уялдуулж, үр дагаврыг үнэлж, тухайн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө, санхүүжилтийн гүйцэтгэлийг эх үүсвэр тус бүрээр бодитой тайлагнах.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГАД:

- Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг хариуцсан байгууллагын чигүүрэг хариуцлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгон давхардлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, нэгтгэн боловсруулах, хэрэгжүүлэх нэгжийн зохион байгуулалт болон хамтран хэрэгжүүлэгч яам, байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо, ажлын хариуцлагыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, тайлан илгээх, хүлээн авах мэдээллийн урсгалыг удирдахад Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн ашиглалтыг сайжруулах;
- Үндсэн чиглэлийн биелэлт, хяналт-шинжилгээ үнэлгээний тайланг төрийн аудитын байгууллагад хагас, бүтэн жилээр ирүүлж байх асуудлыг судалж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагуудад үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн аудитын тайланг хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ДҮНГЭЭС: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН
БОДЛОГЫН ХҮРЭЭНД
ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТ, АРГА
ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

70%

2018 онд **13 зорилт**, арга хэмжээ төлөвлөгдсөнөөс хэрэгжсэн **5**, хэрэгжилт дутуу, эрчимжүүлэх шаардлагатай **8** арга хэмжээ байна.

ДУТУУ ХЭРЭГЖСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

70 ХУВИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ

№	ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨСӨН ТҮВШИН
1	Инфляцийг тогтвортой, нам түвшинд байлгах мөнгөний бодлого хэрэгжүүлэх	Инфляцийн түвшин, оны эцэст, хувиар	6.1
2	Банкны системийн зээлийн эрсдэлд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр иргэдийн санхүүгийн үйлчилгээг тэгш хүртэх эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100
3	Үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, жижиг зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх	Шинээр бий болгох ажлын байрны тоо	45000

40 ХУВИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ

№	ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨСӨН ТҮВШИН
1	Банк, санхүүгийн салбарыг хямралд хүргэж болзошгүй эрсдэлийг нарийвчлан тодорхойлох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100
2	Бизнес эрхлэлтийн санхүүгийн зардлыг бууруулах бодлого хэрэгжүүлэх	Мөнгөний захыг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	10 хувиас багагүй
3	Хөрөнгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, олон нийтийн оролцоог хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох		
4	Засгийн газрын гадаад зээлийн үйлчилгээний төлбөрийг бууруулах хөтөлбөр боловсруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100
5	Үндэсний хэмнэлтийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх		

Хэдийгээр макро түвшний бодлогын үр дүнд эдийн засгийн үзүүлэлт сайжирсан ч хариуцан хэрэгжүүлэгч байгууллагын бодлогын төлөвлөлтийн алдаа, ажлын зохион байгуулалт хангалтгүйгээс үндсэн чиглэлийн зарим зорилт, арга хэмжээ зорилтот түвшинд хүрээгүй байна.




МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ДҮНГЭЭС: БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГЫН ХҮРЭЭНД ТӨЛӨВЛӨСӨН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

65%

2018 онд **18** зорилт, арга хэмжээ төлөвлөгдсөнөөс:



40 ХУВИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨСӨН ТҮВШИН
Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	4
“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах	Төсөл боловсруулах ажлын явц, хувиар	100
Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн цэвэрлэх байгууламж (ЦБ)-ийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх	4 аймгийн ЦБ-ийн барилга угсралтын ажлын явц, хувиар	70
	Улаанбаатар хотын ЦБ-ийн барилгын ажлын явц, хувиар	100
Импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Барилгын гангийн үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар	100
	Дулаан тусгаарлах материалын үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар	50-иас багагүй
	Шилний үйлдвэр байгуулах бэлтгэл ажлын явц, хувиар	10
Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Баруун бүсийн цементийн үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар	30
	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	20-иос доошгүй
	Шинээр болон шинэчлэн боловсруулах стандартын тоо	3-аас багагүй
Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Аюултай хог хаягдлыг устгах байгууламжийн ТЭЗҮ боловсруулах ажлын явц, хувиар	100
	Цахилгааны урамшуулал болон хөнгөлөлттэй үнээр сайжруулсан зуух, боловсруулсан түлш авах өрхийн тоо	40 000-аас багагүй
Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, хамгаалалтыг сайжруулах	Метан хийн хангамжийн мастер төлөвлөгөөний санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх явц, хувиар	100
	Тусгай хамгаалалтад авах газар нутгийн хэмжээ мян.га	600-аас багагүй
Аялал жуулчлалын салбарын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах	Цогцолбор төв байгуулах ажлын явц, хувиар	45
Аялал жуулчлалын бүс нутагт түүхэн болон төрөлжсөн аялал жуулчлалын цогцолбор төв (АЖЦТ) байгуулах	Улаанбаатар, Хэнтий аймагт баригдах АЖЦТ-ийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар	100
	АЖЦТ-ийн барилгын ажлын явц, хувиар	10



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ДҮНГЭЭС: ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ


ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН БИЕЛЭЛТ

75.6%



2018 онд төлөвлөгдсөн **45 зорилт**, арга хэмжээний биелэлт:

40 хувийн хэрэгжилттэй зорилт, арга хэмжээ



40 ХУВИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨСӨН ТҮВШИН
Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн ая тухтай сурч, боловсрох орчин, нөхцөлийг бүрдүүлэх	Гурван ээлжээр хичээллэж буй сургуулийн тоог бууруулах хувь	17
	Орчин нөхцөлийг сайжруулах дотуур байрны тоо	10
Эрдэм шинжилгээ, судалгааг хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх	Эрдэм шинжилгээ, судалгааны зардлын ДНБ-д эзлэх хувь	0.12
Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэгийг өргөтгөх, байгууллагын чадавхыг сайжруулах	Эрүүл мэндийн байгууллагуудад эрсдэлийн нөөцийн сан бүрдүүлэх ажлын явц, хувиар	30
Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, эндэгдлийг бууруулах	100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин, промилль	27
	1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин, промилль	13.7
	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, промилль	16.1

ХЭРЭГЖЭЭГҮЙ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ



Зарим их, дээд сургуулийг Дархан-Уул, Орхон, Багануур, Сэлэнгэ аймагт нүүлгэн шилжүүлэх ажлыг эхлүүлэх



Нийтийн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн үйлчилгээг сайжруулахад төрөөс дэмжлэг үзүүлэх



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ДҮНГЭЭС: ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГЫН БИЕЛЭЛТ

82.9%

2018 онд төлөвлөгдсөн 28 зорилт, арга хэмжээний биелэлт:

- Тодорхой үр дүнд хүрч хэрэгжсэн - 15
- Хэрэгжилт дутуу, эрчимжүүлэх шаардлагатай - 13

ДУТУУ ХЭРЭГЖСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

70 ХУВИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ

№	ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨСӨН ТҮВШИН
1	Архивын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, төрийн архивуудад байгаа баримтыг цахимжуулж, мэдээллийн сан бүрдүүлэх	Шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	1
		Нийт баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын явц, хувиар	22
		Шинэчлэх техник, тоног төхөөрөмжийн хувь	25
2	Гэрч, хохирогчийг хамгаалах, нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	2
3	Мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Хэрэгжүүлэх хөтөлбөрийн тоо	3
4	Хилийн заставын цахилгаан, дулаан хангамжийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр шинэчлэх	Нарны эх үүсвэрээр хангах хилийн заставын тоо	1
5	“Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих”, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	30-аас багагүй
6	Хөрш орнуудтай худалдааг өргөжүүлэх зорилгоор хил дамнансан эдийн засгийн хамтын ажиллагааны чөлөөт бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх	Замын-Үүд-Эрээний чөлөөт бүс байгуулах ажлын явц, хувиар	50
7	Монголын бараа, бүтээгдэхүүнийг таатай нөхцөлөөр экспортлох боломжийг бүрдүүлэх, тариф, хязгаарлалтыг бууруулах	Яриа хэлэлцээр хийх орны тоо	3-аас багагүй
8	Хилийн чанад дахь иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	Цахим үйлчилгээний нэр төрөл, тоогоор	20-иос багагүй
9	Агаарын хил, орон зайн хяналтын системийг сайжруулж, онц чухал объект, цэргийн бүлэглэлийг агаараас халхлах боломжийг нэмэгдүүлэх	Агаарын хил, орон зайн хяналт тавих чадавхын өсөлт, хувиар	10

40 ХУВИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ

1	Шүүхээр шийдвэрлүүлж байгаа хэрэг, маргаан болон хүн амын төвлөрлийг харгалзан шийдвэр гүйцэтгэх чадавхыг бэхжүүлэх	Шинээр байгуулах шийдвэр гүйцэтгэх хэсгийн тоо	3
2	Орчин үеийн эрүүл ахуйн стандартад нийцсэн Шүүх эмнэлгийн байр шинээр байгуулах	Барих байрны тоо	2
3	Төрийн аудитын стандартыг боловсруулж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	2